




УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



УВС
АЙМГИЙН НИЙГЭМ
ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙДАЛ

2021 / 01



Улаангом хот

**УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

**УВС АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙДАЛ**

**1 сар
2021**

Улаангом хот

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН ХААНААС АВАХ ВЭ?

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах тоглоом 

Валютын ханш 



©2017

аппликейшнаас

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ АВААРАЙ

Data lab

тооллого судалгааны микро мэдээллийн сан



Social network

 www.facebook.com/StatisticMongolia/


 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	4
Статистик мэдээллийн өнгө, таних тэмдэг	5
Хэрэглэгчдэд лавлагаа	7
Товч танилцуулга.....	8
Үндсэн үзүүлэлт	31
IV.Хөдөлмөр.....	37
VI. Нийгмийн даатгал, халамж.....	42
VIII. Эрүүл мэнд	46
XI. Байгаль орчин	48
XII. Гэмт хэрэг.....	51
XIV.Мөнгө, зээл.....	54
XV.Төрийн санхүү	56
XVI.Гадаад худалдаа.....	59
XVII. Үнэ	60
XVIII.Хөдөө аж ахуй	62
XIX. Аж үйлдвэр... ..	65

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III , IV, V..... г.м)
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.

2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :
... мэдээлэл байхгүй
0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй
Д - дахин

3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

4. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд танилцуулга дээрх QR кодыг ашиглан дэлгэрэнгүй мэдээллийг uvs.nso.mn сайтаас татан авч ашиглаж болно.



Үндэсний статистикийн хорооны даргын
2013 оны 12 сарын 06 өдрийн 113-р тоот
тушаалын гуравдугаар хавсралт

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ӨНГӨ, ТАНИХ ТЭМДЭГ

Д/д	Таних тэмдэг	Мэдээллийн нэр	Өнгө	Вэбийн өнгө R/G/B	Хэвлэлийн өнгө S/M/Y/K
1		Засаг захиргаа, нутаг дэвсгэр	Шар	255/212/0	0/15/100/0
2		Сонгууль	Шар	255/212/0	0/15/100/0
3		Хүн ам	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
4		Хөдөлмөр	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
5		Хүн амын амьжиргаа	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
6		Нийгмийн даатгал, халамж	Улаан	217/31/61	10/100/80/0
7		Боловсрол, шинжлэх ухаан	Шар	255/212/0	0/15/100/0
8		Эрүүл мэнд	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
9		Хүний хөгжил	Улаан	217/31/61	10/100/80/0
10		Соёл, аялал жуулчлал, биеийн тамир, спорт	Шар	255/212/0	0/15/100/0
11		Байгаль орчин	Ногоон	14/178/76	80/0/100/0
12		Гэмт хэрэг	Улаан	217/31/61	10/100/80/0

Д/д	Таних тэмдэг	Мэдээллийн нэр	Өнгө	Вэб-д R/G/B	Хэвлэлд S/M/Y/K
13		Үндэсний тооцоо	Хөх	23/71/158	100/85/0/0
14		Мөнгө, банк, даатгал	Хөх	23/71/158	100/85/0/0
15		Төрийн санхүү	Хөх	23/71/158	100/85/0/0
16		Төлбөрийн тэнцэл, гадаад худалдаа	Хөх	23/71/158	100/85/0/0
17		Үнэ	Хөх	23/71/158	100/85/0/0
18		Хөдөө аж ахуй	Улбар шар	248/165/26	0/40/100/0
19		Аж үйлдвэр	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
20		Тээвэр, харилцаа, холбоо	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
21		Худалдаа, үйлчилгээ	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
22		Барилга, орон сууц, нийтийн аж ахуй	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
23		Бизнес регистр	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
24		Дэлхийн улс орнуудын хөгжил	Хөх цэнхэр	64/133/197	75/40/0/0

Хэрэглэгчдэд зориулсан лавлагаа:

Аймгийн Статистикийн хэлтсээс гаргаж буй дараахь мэдээлэл, танилцуулга, тооллого, түүвэр судалгааны үр дүнг uvs.nso.mn хаягаар орох болон аймгийн Засаг даргын Тамгын газрын II байранд байрлуулсан электрон самбарыг ашиглан үзэж, холбогдох мэдээллээ авч болно. Үүнд :

- ✚ Аймгийн нийгэм эдийн засгийн байдлын танилцуулгууд
- ✚ Ажиллах хүчний үр дүнгийн танилцуулга
- ✚ Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгааны үр дүн
- ✚ 2010 оны Хүн ам орон сууцны тооллогын үр дүн, сум, багаар
- ✚ Аж ахуйн нэгжийн тооллогын үр дүн, аймгуудаар, сумдаар, 2010 он
- ✚ Судалгааны үр дүнгүүд
- ✚ 2013-2018 оны ХАА-н салбарын танилцуулга,
- ✚ 2013 -2018 оны Хүн ам, өрхийн төлөв байдал сэдэвт танилцуулга
- ✚ 2013-2018 оны Аймгийн үйлдвэр, үйлчилгээний салбарын танилцуулга
- ✚ 2013-2018 оны Хүн амын ажил эрхлэлтийн танилцуулга
- ✚ Аймгийн ДНБ үйлдвэрлэлт-2014 онд
- ✚ 2016 оны сар бүрийн танилцуулгууд
- ✚ 2017 оны сар бүрийн танилцуулгууд
- ✚ 2018 оны сар бүрийн танилцуулгууд
- ✚ Хүн амын хүрээлэн буй орчны танилцуулга
- ✚ Статистикийн эмхэтгэлүүд
- ✚ Статистикийн өврийн дэвтрүүд
- ✚ 2019 оны сар бүрийн танилцуулгууд
- ✚ 2020 оны сар бүрийн танилцуулгууд
- ✚ 2021 оны сар бүрийн танилцуулгууд

Улс, аймгийн мэдээлэл авах хаяг: uvs.nso.mn www.uvs.gov.mn

Мэдээллийн сангаас авах бол: www.1212.mn

Увс аймгийн Статистикийн хэлтсийн ажилтнуудтай харилцах хаяг :

uvs@nso.mn (албаны хаяг)

Утас: 92037373, 92031122, 99906004, 89610610, 99760175, 92033444






III. ХҮН АМ


3.1 Хүн ам

Аймгийн хэмжээнд 2021 оны 1 сард 134 эх амаржиж, 133 хүүхэд төрж, мөн нас баралт 18 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 20 (13.0%) - оор, төрсөн хүүхэд 19 (12.5%) – өөр, нас баралт 15 (45.5%)-аар тус тус буурчээ. 1000 хүнд ноогдох төрөлт 1.6, нас баралт 0.2, цэвэр өсөлт 1.4 болов. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1000 хүнд ноогдох төрөлт 0.3 пунктээр, цэвэр өсөлт 0.1 пунктээр, нас баралт 0.2 пунктээр тус тус буурсан байна.

Зураг 3.1 Төрсөн хүүхдийн тоо, онуудаар



Зураг 3.2 1000 хүнд ноогдох төрөлт, нас баралт, цэвэр өсөлт, жил бүрийн эхний 1 сарын байдлаар



1000 хүн амд ноогдох төрөлтийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 0.2 пунктээр, нас баралтын тоо 0.2 пунктээр тус тус буурчээ.

Гэрийн төрөлт гараагүй байна. Нийт нас баралтын 22.2 хувийг эмнэлгийн нас баралт эзэлж өмнөх оны мөн үеэс 7 пунктээр өссөн байна.




IV. ХӨДӨЛМӨР

4.1 Шинэ ажлын байр болон бүртгэлтэй ажилгүйчүүд

Энэ оны эхний 1 сард аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 790 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 9 (1.1%) хүнээр буурсан байна. Аймгийн хэмжээнд 414 эмэгтэй ажил идэвхитэй эрж байгаа нь ажилгүйчүүдийн 52.4 хувийг эзэлж байна.

2021 оны эхний 1 сард бүртгүүлсэн, ажил идэвхитэй эрж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 104 (15.2%) ажилгүйчүүдээр буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 21 (2.7%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.


Зураг 4.1 Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, сүүлийн 4 жилээр



Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт энэ оны эхний 1 сард 147 ажилгүй иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан ажилгүйчүүдээс 23 иргэн ажилд зуучлагдан орж, 188 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагджээ.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 11.8 хувь нь 15-24 насны, 46.3 хувь нь 25-34 насны, 24.9 хувь нь 35-44 насны, 14.7 хувь нь 45-54 насны, 1.9 хувь нь 55-59 насны, 0.4 хувь нь 60 дээш насны ажилгүйчүүд байна. Ажилгүйчүүдийн 28.7 хувь нь дээд, 13.1 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 46.1 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 12.1 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс байна.

Зураг 4.2 Бүртгэлтэй ажилгүйчүүд боловсролын түвшингээр




2021 оны 1 дүгээр сард 44 ажлын байрны захиалга ирснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 53 (2.2дахин) буурсан байна.

Зураг 4.3 Ажлын байрны захиалга, ажилд орсон хүний тоо



Ажлын байрны захиалгыг эдийн засгийн ангиллаар нь авч үзвэл: үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар 29.5 хувь, боловсролын салбар 27.3 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбар 18.2 хувь, бусад салбар 25.0 хувийг эзэлж байна.

Зураг 4.4 Ажлын байрны захиалга салбарын ангиллаар , хувь




Ажлын байрны захиалгын 6.8 хувь нь менежер, 54.5 хувь нь мэргэжилтэний, 13.6 хувь нь техникч болон туслах дэд мэргэжилтэний, 2.3 хувь нь контор үйлчилгээний ажилтны, 6.8 хувь нь үйлдвэрлэл, барилгын ажилтны, 13.6 худалдаа үйлчилгээний ажилтны, 2.3 нь бусад албан тушаалын захиалга байлаа.

Зураг 4.5 Ажлын байрны захиалгын эзлэх хувь, ажил мэргэжлийн ангиллаар



Байнгын шинэ ажлын байранд 8 хүн ажилд орсны 37.5 хувь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 12.5 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 12.5 хувь нь усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, 12.5 хувь нь боловсрол, 25.0 хувь нь бусад салбарт тус тус ажилд орсон байна.

Зураг 4.6 Ажлын шинэ байранд ажилд орсон хүний эзлэх хувь, салбараар



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР


Бүртгэлтэй ажилгүй иргэн: Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.



VI НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 1 сард 1540.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 92.6 (5.7%) сая төгрөгөөр буурч, сангийн зарлага 5413.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 308.4 (6.0%) сая төгрөгөөр өслөө. Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеэс 308.4 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 707.0 сая төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлжээ.


Зураг 6.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага эхний 1 сард, сая төгрөг



Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлт бүх сумдад 84.2 хувьтай байна.


Нийгмийн даатгалын сан 664.1 сая төгрөгийн авлагатай байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 28.3 (4.5%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт авлагын 6.9 хувийг төсөвт байгууллагын өглөг эзэлж байна.

Зураг 6.2 Нийгмийн даатгалын сангийн орлого, сангуудаар, сая төгрөг




Сангуудаар авч үзвэл өмнөх оны мөн үеэс эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 53.4 (15.9%), ҮОМШӨ –ний даатгалын сангийн орлого 25.8 (27.4%) , тэтгэмжийн даатгалын сангийн орлого 8.5 (7.2%), ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 4.6 (19.2%) сая төгрөгөөр тус тус буурч, тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Зураг 6.3 Нийгмийн даатгалын сангийн зарлага, сангуудаар, сая төгрөг




Өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн зарлага 707.0 (17.5%), тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 50.7 (26.9%) сая, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага 1.4 (17.9%) сая, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 44.4 (2.7дахин) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 495.1 (59.2%) –иар буурчээ.

Зураг 6.4 Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувиар



Нийгмийн халамжийн сангаас энэ оны эхний 1 сард 12.8 мянган хүнд 854.5 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеэс олгосон тэтгэвэр тэтгэмж 25.3 (2.9%) сая төгрөгөөр буурч, орон нутгийн нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж авагчид 4.6 (26.6%) мянган хүнээр буурсан байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт энэ оны эхний 1 сард 1.6 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 7 (0.4%) хүнээр буурч, олгосон тэтгэвэр 181.4 (62.8%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг 6.5 Халамжийн сангийн зарцуулалт, жил бүрийн эхний 1 сарын байдлаар, сая төгрөг



Энэ оны 1 сард хүнс тэжээл хөтөлбөрт 8725 хүн хамрагдаж, 106.8 сая төгрөгийн тусламж авчээ.

Асрамжийн газар нийт 16 хүн асруулж байгаа бөгөөд 11 эмэгтэй байна. Асрамжийн үйл ажиллагаанд нийт 17.9 сая төгрөгийг зарцуулжээ.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ


Даатгуулагч: Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг ойлгоно.



VIII. ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл 1 сард 2 гарч, 1000 амьд төрөлтөнд нялхсын эндэгдэл 15.0 ноогдож байна.

Зураг 8.1 1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдэл, сараар




Зураг 8.2 1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын ба 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл




1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдэл Улаангом суманд 17.1, аймгийн дундаж 15.0 байна.

Зураг 8.3 1000 амьд төрөлтөд ноогдох нялхсын эндэгдлийн түвшин, сумаар



Зураг 8.4 1000 амьд төрөлтөд ноогдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, сумаар



Эхний 1 сарын байдлаар осол гэмтлийн улмаас 3 хүн нас барж, өвчлөгчдийн тоо 58 болсон нь өмнөх оны мөн үеэс өвчлөгчдийн тоо 13 (28.9%) – аар, нас баралтын тоо 2 – оор тус тус өссөн байна. Өмнөх 3 жилийн дунджаас осол гэмтлээр өвчлөгчдийн тоо 2.2 хувиар буурч, осол гэмтлийн нас баралтын тоо 30.4 хувиар өссөн байна.

Зураг 8.5 Осол гэмтлийн өвчлөл, нас баралтын тоо




Хорт хавдрын өвчлөл 5 гарч өмнөх оны мөн үеэс 2 (28.6%)-оор, нас баралт 3 гарсан нь өмнөх оны мөн үеэс 8 (72.7%) - аар тус тус буурчээ.

Зураг 8.6 Хорт хавдрын өвчлөл, нас баралтын тоо



Эхний 1 сард халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 20 болж өнгөрсөн оны мөн үеэс 40 (66.7%) хүнээр буурч, өмнөх 3 жилийн мөн үеийн дунджаас 72.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Зураг 8.7 Халдварт өвчний гаралт, тоогоор




Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнийг хувиар авч үзвэл гепатит өвчин нийт халдварт өвчний 5.0, БЗХӨ 60.0, сүрьеэ 35.0 хувийг эзэлж байна.

Өмнөх оны мөн үеэс БЗХӨ - ний эзлэх хувь 21.7 хувиар тус тус буурч, сүрьеэ өвчний эзлэх хувь 31.7 хувиар өссөн байна. Бусад халдварт өвчин гараагүй байна.

Зураг 8.8 Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд, хувиар, 2021 I сар



Зураг 8.9 Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд 2020 I сар




10000 хүн тутмаас 2 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд Давст 12.4, Цагаанхайрхан 9.7, Улаангом 4.4, Өлгий 4.1 байгаа нь аймгийн дунджаас 1.7 – 10.0 процентийг өндөр, Тэс сум 2.0 байгаа нь аймгийн дунджаас 0.4 процентийг бага байна. Бусад сумдад халдварт өвчний тохиолдол гараагүй байна.

Зураг 8.10 10000 хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд



Зураг 8.11 10000 хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд



Амбулаториор 32.5 мянган хүнд үзлэг хийгдэж, 1.7 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн байна.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

ЭРҮҮЛ МЭНД

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байгааг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нялхсын эндэгдлийн түвшин: Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин: Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшин: Тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны дундаж хүн амын тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндэснийг хамруулна.



XI. Байгаль орчин

Энэ оны 1 - р сард агаарын температур дунджаар Зүүнговь, Тэс, Ховд сумдад -32.9 аас -33.5 градустай, бусад сумдад -17.6 аас -31.8 градус хүйтэн байсан байна. Хөрсний гадаргын дундаж температур Давстад хамгийн хүйтэн -33.6 градус байсан бол хамгийн бага температуртай нь Өмнөговь суманд -18.2 градус байжээ. Салхины хамгийн их хурд Өмнөговь суманд 22 м/сек хүрсэн бөгөөд 10 м/сек-ээс их салхитай өдөр Өмнөговь 17, Өлгий 11, Өндөрхангай 7, Зүүнговь 5, Бөхмөрөн, Завхан, Наранбулаг, Түргэн, Хяргас сумдад 1 өдөр байв.

Хяргас суманд 7.1 мм хур тунадас орсон нь бусдаас илүү байна. Хур тунадастай өдөр хамгийн олон нь Өндөрхангай 9 өдөр байлаа.

Агаарын чанарын мэдээгээр хүлцэх агууламжаас давсан тохиолдол 7 байсан байна. Өнгөрсөн оны мөн үеэс тоос /PM 10/ 0.033 мг/м³, азотын давхар исэл 0.006 мг/м³, хүхэрлэг хий 0.004 мг/м³ –аар тус тус бага байлаа.

Аюулт үзэгдэл, ослын мэдээ

2021 оны 1 дүгээр сард хүчтэй, салхи шуурганы аюулт үзэгдлийн тохиолдол 2, газар хөдлөлтийн аюулт үзэгдлийн тохиолдол 1, эрэн хайх, аврах ажиллагааны дуудлага 1, объектын гал түймэр 13 гарсан байна. Эдгээр гамшиг осол, гал түймрийн улмаас иргэдийн хувийн өмчинд 37.7 сая төгрөгийн хохирол учирч, гамшиг осол, гал түймрийн аюулаас иргэдийн 5.0 сая төгрөгийн эд хөрөнгийн авран хамгаалжээ.




XII. ГЭМТ ХЭРЭГ, ШҮҮХ

12.1 Гэмт хэргийн статистик

Энэ оны 1 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 22 болж өнгөрсөн оны мөн үеэс 2 (10.0%)-оор өсчээ. Гэмт хэргийн улмаас 8 хүн гэмтэж, 24 иргэн хохирсон байна.


Зураг 12.1 Гэмт хэргийн гаралт, жил бүрийн эцэст



Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 11.1 хувиар буурч, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 33.3 хувиар өсчээ.

Гэмт хэргийг үйлдэгдсэн байдлаар нь авч үзвэл гэр бүлийн хүчирхийллийн улмаас 1, согтуугаар үйлдэгдсэн 3, гудамж талбайд 1, гэр орон сууцанд 6 гэмт хэрэг гарсан байна.

Зураг 12.2 Гэмт хэргийн гаралт, төрлөөр, тоо




Гэмт хэрэг үйлдсэн хүний тоо 10 болж, өмнөх оноос 4 хүнээр өссөн байна. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдлаар авч үзвэл 1 эмэгтэй оролцож, хүүхэд оролцсон хэрэг гараагүй байна.

Гэмт хэргийн улмаас 145.7 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 122.6 (бдахин) сая төгрөгөөр өсч, иргэд байгууллагад учруулсан нийт хохирлын 7.3

сая төгрөг буюу 5.0 хувийг нөхөн төлүүлжээ. Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын үед 1 хөрөнгө битүүмжилсэн байна.

Зураг 12.3 Хохирол, нөхөн төлөлт сая.төгрөг




Энэ оны 1 сард Улаангом суманд 7 хэрэг үйлдэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 46.2 хувиар буурчээ. Аймгийн хэмжээнд нийт 922 зөрчил шийдвэрлэсэн нь өнгөрсөн оноос 194 (17.4%) зөрчлөөр буурсан байна. Энэ оны 1 сард 28 хүн тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж торгуулжээ.

12.2 Шүүхийн статистик


Аймгийн шүүхийн тамгын газраас ирүүлсэн мэдээллээр, энэ оны 1 сард шүүхээр нийт 95 хэрэг шийдвэрлэжээ. Шүүхийн төрлөөр авч үзвэл эрүүгийн хэрэг 11, иргэний хэрэг 78, давж заалдах шатны шүүхээр 3, захиргааны 3 хэрэг тус тус шийдвэрлэсэн байна.

Зураг 12.4 Шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргийн тоо, шүүхийн төрлөөр



Шүүхээр ял шийтгүүлсэн нийт 15 иргэн, үүнээс хорих ял шийтгүүлсэн 9 иргэн байна.

Зураг 12.5 Ял шийтгүүлсэн хүний тоо, насны бүлгээр



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

ГЭМТ ХЭРЭГ

Гэмт хэрэг: Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

18, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18, түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулж тооцно.

Гэмт хэргийн хохирогч: Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг ойлгоно /МУ-ын "Эрүүгийн байцаан шийтгэх" хуулийн 42.1 дэх заалт/.

Учирсан хохирол: Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эдийн болон эдийн бус хөрөнгийн эрхэд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Нөхөн төлбөр: Хохирлын нөхөн төлүүлэлт нь хүний эрх, эрх чөлөөний хир хэмжээ, учруулсан хор уршигт дүйцэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургууль, боловсролын түвшинг аль болох өмнө нь байсан хэмжээнд сэргээн бүрдүүлэхийг ойлгоно.

Сэжигтэн: МУ-ын "Эрүүгийн байцаан шийтгэх" хуулийн 35.1-д заасны дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэж, дор дурдсан этгээдийг сэжигтнээр тооцож, үндэслэл бүхий тогтоол гаргана уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан; гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан; уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон; уг этгээд хэргээ илчлэн ирсэн гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол.

Яллагдагч: МУ-ын "Эрүүгийн байцаан шийтгэх" хуулийн 36.1-д заасны дагуу энэ хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг ойлгоно.




XIV. МӨНГӨ, БАНК

Монгол банкны мэдээгээр зээлийн өрийн үлдэгдэл 163.9 тэрбум төгрөгт хүрч, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 3.2 тэрбум төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 24.9 (13.2 %) тэрбум төгрөгөөр буурч, хугацаа хэтэрсэн зээл 790.1 (33.3 %) сая төгрөгөөр өссөн байна.


6.4 тэрбум төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.9 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 969.8 (13.2 %) сая төгрөгөөр буурсан байна.

Зураг 14.1 Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, тэрбум төгрөг



Нийт хадгаламжийн үлдэгдэл 178.4 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 53.2 (42.5 %) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 14.2 Нийт хадгаламжийн үлдэгдэл, тэрбум төгрөг



Нийт хадгаламжийн үлдэгдлийн 76.2 хувь нь хугацаатай, 23.8 хувь нь хугацаагүй хадгаламж байна. Хадгаламж эзэмшигчдийн тоо 80.2 мянгад хүрсэн байна.




15.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор 2021 оны 1 дүгээр сард аймгийн төсөвт 2021.4 сая төгрөг оруулахаас 2088.3 сая төгрөгийн орлого орж төлөвлөгөөний биелэлт 103.3 хувьтай, 66.9 (3.3%) сая төгрөгөөр давуулан биелүүллээ.

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 1163.3 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 1022.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 140.9 (12.1%) сая төгрөгөөр тасалсан байна. Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 473.6 сая төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 265.9 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 207.7 (43.9%) сая төгрөгөөр тасалж, аймгийн төсөвт өөрийн орлогоор 689.7 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 756.5 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 66.8 (9.7%) сая төгрөгөөр давуулан биелүүллээ. Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймгийн төвлөрүүлсэн нийт орлого 153.2 (13.0%) сая төгрөгөөр бага, үүнээс улсын төсөвт төвлөрүүлсэн орлого 143.9 (35.1%) сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлсэн орлого 9.3 (1.2%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.


2021 оны 1 дүгээр сард улсын төсөвт төвлөрүүлэх орлогуудаас ААНБ-ын орлогын албан татварын төлөвлөгөө 19.9 (84.7%) сая төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн татвар 153.9 (39.5%) сая төгрөгөөр, онцгой албан татвар 0.4 (3.8%) сая төгрөгөөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 15.0 (62.2%) сая төгрөгөөр, агаарын бохирдлын төлбөр 18.5 (72.7) сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Зураг 15.1 Төсвийн орлогын бүтэц, хувиар



Аймгийн төсвийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 13.0 хувиар буурч, өмнөх 3 жилийн дундажтай харьцуулахад 12.3 хувиар өссөн байна.


Зураг 15.2 Төсвийн орлогын өсөлт бууралт, онуудаар, сая төгрөг




15.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 4.5 тэрбум төгрөгийн зардал гаргасан нь өнгөрсөн оны мөн үеэс 11.6 хувиар буурчээ.

Зураг 15.4 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөг



Зураг 15.5 Төсвийн зарлагын бүтэц, хувь




Төсвийн зарлагын 69.6 хувийг цалин, 8.1 хувийг НДШ, 4.2 хувийг урсгал шилжүүлэг, 21.3 хувийг бусад зарлага, 0.9 хувийг урсгал шилжүүлэг, 0.1 хувийг хөрөнгө оруулалт эзлэж байна.

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА


Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр 2021 оны 1 сард 5.6 сая төгрөгийн өртэй, 47.5 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Зураг 15.6 Төсөвт байгууллагуудын өглөг, авлага

Төсөвт байгууллагуудын өглөг жил бүрийн 1 сарын эцэст, сая.төгрөг



Төсөвт байгууллагуудын авлага жил бүрийн 1 сарын эцэст, сая.төгрөг






XVI. ГАДААД ХУДАЛДАА

Оны эхний 1 сард импорт 555.3 мянган америк долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1823.5 (76.7 %) мянган америк доллараар буурсан байна. Гол нэрээс дурдвал 555.3 мянган киловатт цаг цахилгаан импортоор оруулсан байна.

Зураг 1 Нийт импорт,экспорт жил бүрийн эцэст мян.ам.доллар



Энэ оны эхний 1 сард экспортлосон бараа бүтээгдэхүүн байхгүй байна.




XVII. ҮНЭ

17.1 Хэрэглээний үнэ


Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлэг, сагсны 238 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж сарын инфляци тооцож байдаг. Энэ оны 1-р сарын 15-21 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын ерөнхий индекс өнгөрсөн оны мөн үеэс 4.6 хувь, өмнөх оны эцсээс 1.5 хувиар, өмнөх сараас 1.5 хувиар тус тус өссөн байна.

Зураг 17.1 Үнийн өөрчлөлт бүлгээр




Өмнөх сараас хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 4.1 хувиар, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 0.1 хувиар, хувцас бөс барааны бүлгийн үнэ 0.8, эм тарианы бүлгийн үнэ 0.5, гэр ахуйн тавилгын үнэ 0.8 хувиар, амралт чөлөөт цаг соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ 0.3 хувиар, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 1.0 хувиар тус тус өсч, бусад бүлгийн үнэ тогтвортой байсан байна.

Зураг 17.2. Сүүлийн 4 жилийн индексийг өмнөх сар, оны эхтэй харьцуулсан индекс



Сүүлийн 4 жилийн 1-р сарыг өмнөх оны эцэс болон өмнөх сартай харьцуулсан индексээс харахад хамгийн өндөр нь 2021 оны 1-р сард 1.5 хувь, хамгийн бага нь 2020 оны 1-р сард 0.7 хувь өсч байсан үзүүлэлттэй тооцогдож байна.

Зураг 17.3. Сарын инфляцийн түвшин




Өргөн хэрэглээний 12 бараа, бүтээгдэхүүний үнийг 7 хоног бүрийн 3 дахь өдөр цуглуулж өөрчлөлтийг судалж байна.



Махны дундаж үнэ:

2021 оны 1-р сард хонины мах сүүлийн 4 дэх долоо хоногоос 166 төгрөгөөр, үхрийн мах 4 дэх долоо хоногоос 500 төгрөгөөр тус тус өсч, ямааны махны дундаж үнэ сарын турш тогтвортой байлаа.

Зураг 17.4. Махны үнэ, долоо хоногоор, төрлөөр



1-р сард дунджаар 1 кг хонины мах 8500, үхрийн мах 8583, ямааны мах 7000, 1 л шингэн сүү 2300 төгрөг, элсэн чихэр 2600 төгрөг, цагаан будаа 2333 төгрөг, бензин А-80 1513, А-92 1613, дизель түлш 1950 төгрөгийн дундаж үнэтэй байсан байна.





XVIII. ХӨДӨӨ АЖ АХУЙ



18.1 Том малын зүй бусын хорогдол

Оны эхний малын 0.01 хувь буюу 0.2 мянган толгой мал хорогдсон нь өнгөрсөн онохоос 92.3 хувь буюу 2233 толгойгоор буурсан байна.

Зураг 18.1 Том малын хорогдол,

Зураг 18.2 Нийт хорогдолд эзлэх хувь


мянган толгой



Нийт хорогдлын 43.3 хувийг хонь, 38.5 хувийг ямаа, 10.7 хувийг адуу, 7.5 хувийг үхрийн хорогдол эзэлж байна.

Зураг 18.3 Зүй бусаар хорогдсон мал оны эхний малд эзлэх хувь,

сумаар, 2021 оны 1 сарын байдлаар



Хорогдсон том мал оны эхний малд эзлэх хувийг сумдаар авч үзвэл : Өлгий, Хяргас, Баруунтуруун, Давст, Бөхмөрөн, Өндөрхангай сумын 0.01 – 0.04 хувь хорогдсон нь аймгийн дунджаас 0.01 – 0.03 пунктээр их, бусад суманд малын хорогдол гараагүй байна.


Өвчнөөр хорогдсон мал 96 болж, өмнөх оны мөн үеэс 57 (2.4 дахин) толгойгоор өсчээ.




XIX АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжүүд энэ оны эхний 1 сард оны үнээр 1.9 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж 2.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үеэс үйлдвэрлэлт 12.7 хувиар, бүтээгдэхүүний борлуулалт 38.4 хувиар өссөн байна.

Зураг 19.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт, оны үнээр, тэрбум төгрөгөөр




Зураг 19.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт салбараар, оны үнээр, тэрбум төгрөгөөр



Өнгөрсөн оны мөн үеэс уул уурхайн олборлолт 54.6, дулаан усан хангамж 24.2 хувиар өсч, боловсруулах салбарын үйлдвэрлэл 28.2 хувиар буурсан байна.

Нийт үйлдвэрлэлтийн 65.9 хувийг дулаан түгээлт, усан хангамж, хог зайлуулалт, 18.2 хувийг боловсруулах салбарын үйлдвэрлэл, 15.9 хувийг уул уурхайн олборлолт эзэлж байна.

Зураг 19.2 Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн салбарын бүтэц, хувь



Аж үйлдвэрийн салбарын ажиллагсдын тоо 748 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 3.0 хувиар өссөн байна.

Энэ онд аж ахуйн нэгжүүд 57 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд өсөлт гарч үүнээс өмнөх оны мөн үед үйлдвэрлэгдэж байгаагүй 21 нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн байна.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

АЖ ҮЙЛДВЭР

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

П.ТУНГАЛАГ



2021 оны 2 дугаар сарын 10

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2021 оны эхний 1 сар

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	хэмжих нэгж	2018 I	2019 I	2020 I	2021 I
Төрсөн хүүхдийн тоо	амьд төрөлт	▲ 153 ^{14.2}	▼ 134 ^{-12.4}	▲ 152 ^{13.4}	▼ 133 ^{-12.5}
Нас баралт	тоо	▲ 35 ^{34.6}	▲ 41 ^{17.1}	▼ 33 ^{-19.5}	▼ 18 ^{-45.5}
0- 5 насны хүүхдийн эндэгдэл	тоо	▲ 3	▲ 5 ^{1.7д}	▼ 2 ^{-60.0}	■ 2 ^{0.0}
0-1 насны хүүхдийн эндэгдэл	тоо	▲ 3	■ 3	▼ 2 ^{-33.3}	■ 2 ^{0.0}
Халдварт өвчний гаралт	тоо	▲ 109 ^{147.7}	▼ 50 ^{-54.1}	▲ 60 ^{20.0}	▼ 20 ^{-66.7}
10000 хүнд ноогдох халдварт өвчин	тоо	▲ 7.8 ^{44.4}	▼ 6.1 ^{-21.8}	▲ 7.26 ^{19.0}	▼ 2 ^{-66.9}
Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	тоо	▼ 29 ^{-32.6}	▼ 24 ^{-17.2}	▼ 20 ^{-16.7}	▲ 22 ^{10.0}
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо,сарын эцэст	хүн	▼ 574 ^{-51.5}	▲ 685 ^{19.3}	▲ 799 ^{16.6}	▼ 790 ^{-1.1}
үүнээс эмэгтэй	хүн	▼ 258 ^{-61.1}	▲ 366 ^{41.9}	▲ 427 ^{16.7}	▼ 414 ^{-3.0}
Нийгмийн даатгалын сангийн орлого	сая.төг	▼ 866.4 ^{-4.6}	▲ 1218.7 ^{40.7}	▲ 1633 ^{34.0}	▼ 1540.4 ^{-5.7}
Нийгмийн даатгалын сангийн зарлага	сая.төг	▲ 3256.4 ^{4.7}	▲ 4162.1 ^{27.8}	▲ 5105.4 ^{22.7}	▲ 5413.7 ^{6.0}
Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ	сая.төг	▲ 3050.4 ^{3.5}	▲ 3591.1 ^{17.7}	▲ 4047.1 ^{12.7}	▲ 4754.1 ^{17.5}
Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ	сая.төг	▲ 864.3 ^{30.5}	▲ 2313.6 ^{167.7}	▼ 288.7 ^{-87.5}	▲ 470.1 ^{62.8}
Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан хүн	хүн	▲ 14170 ^{44.4}	▲ 25270 ^{78.3}	▼ 17380 ^{-31.2}	▼ 12755 ^{-26.6}
Аймгийн төсвийн орлого,оны үнээр	сая.төг	▲ 748.2 ^{40.9}	▲ 927.7 ^{24.0}	▲ 1175.5 ^{26.7}	▲ 1022.4 ^{-13.0}
Төсвийн зарлага,оны үнээр	сая.төг	▼ 3519.7 ^{-10.9}	▼ 4736.7 ^{34.6}	▲ 5068.8 ^{7.0}	▼ 4480.9 ^{-11.6}
Төсвийн өглөг	сая.төг	▼ 0 ^{-100.0}	▲ 36.1	▼ 0	▲ 5.6
Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны эцэстэй харьцуулсан)	хувь	▲ 101	▲ 100.7	▲ 100.0	▲ 101.5
Хэрэглээний үнийн индекс (өмнөх сартай харьцуулсан)	хувь	▲ 101	▲ 100.7	▲ 100.0	▲ 101.5
Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны мөн үетэй харьцуулсан)	хувь	▲ 101	▲ 100.7	▲ 107.5	▲ 104.6
Банкны зээлийн үлдэгдэл	тэрбум.төг	▲ 173.1 ^{9.9}	▲ 197.6 ^{14.2}	▼ 188.7 ^{-4.5}	▼ 163.9 ^{-13.1}
Үүнээс: хугацаа хэтэрсэн	тэрбум.төг	▲ 5.2 ^{44.4}	▼ 2.3 ^{-55.8}	▲ 2.4 ^{4.3}	▲ 3.2 ^{33.3}
Хадгаламжийн үлдэгдэл	тэрбум.төг	▲ 91.1 ^{44.6}	▲ 107.2 ^{17.7}	▲ 125.1 ^{16.7}	▲ 178.4 ^{42.6}
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл оны үнээр	сая.төг	▲ 1445.1 ^{1052.4}	▼ 1278.1 ^{-11.6}	▲ 1682.7 ^{31.7}	▲ 1896.9 ^{12.7}
Уул уурхай олборлох үйлдвэр	сая.төг	▼ 160.1 ^{-9.1}	▼ 116.1 ^{-27.5}	▲ 194.6 ^{67.6}	▲ 300.9 ^{54.6}
Боловсруулах аж үйлдвэр	сая.төг	▲ 486.8 ^{204.6}	▼ 297.5 ^{-38.9}	▲ 481.2 ^{61.7}	▼ 345.3 ^{-28.2}
дулаан түгээлт, усан хангамж	сая.төг	▼ 798.2 ^{15.8}	▲ 865.2 ^{8.4}	▲ 1006.9 ^{16.4}	▲ 1250.7 ^{24.2}
Аж үйлдвэрийн борлуулалт, оны үнээр	сая.төг	▲ 1418.5 ^{35.4}	▼ 1353.0 ^{-4.6}	▲ 1507.0 ^{11.4}	▲ 2086.2 ^{38.4}
Том малын хорогдол бүгд	мян.тол	▲ 8.1 ^{125.0}	▼ 2.1 ^{-74.1}	▲ 2.4 ^{14.3}	▼ 0.2 ^{-91.7}

▲▲ эерэг хандлага, эерэг өөрчлөлт
▼▼ сөрөг хандлага, сөрөг өөрчлөлт

Сумдын эдийн засаг нийгмийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд, 2021 оны эхний 1 сар

(сумдаар)

сумдын нэр	Татварын орлого	Төсвийн орлогын ТБ	Гарсан гэмт хэрэг бүгд	НДС-ийн		Хорогдсон малын тоо
				орлого*	ТБ %	
хэмжих нэгж	сая.төг	хувь	тоо	сая.төг	хувь	тоо
ДҮН	1175.5	134.8	22	1258.0	82.4	187
Баруунтуруун	30.7	166.1	1	60.4	82.4	20
Бөхмөрөн	22.5	145.3		6.3	82.4	19
Давст	7.9	135.0		17.0	82.4	22
Завхан	18.4	141.1		16.7	82.4	
Зүүнговь	9.8		1	19.8	82.4	
Зүүнхангай	16.4	88.8	1	17.5	82.4	
Малчин	7.2	117.8	1	33.1	82.4	
Наранбулаг	12.3	71.6	2	31.5	82.4	
Өлгий	9.3	145.9	2	6.4	82.4	50
Өмнеговь	21.0	131.9	3	37.9	82.4	
Өндөрхангай	16.4	155.5		28.0	82.4	27
Сагил	12.6	129.9	1	25.5	82.4	
Тариалан	17.7	182.1		35.2	82.4	2
Түргэн	8.8	125.9		19.9	82.4	
Тэс	19.0	125.6	1	27.7	82.4	
Ховд	9.1	84.1	1	24.6	82.4	
Хяргас	12.1	103.0		27.8	82.4	47
Цагаанхайрхан	14.1	130.8	1	22.2	82.4	
Улаангом	910.5	159.2	7	800.5	82.4	
2020 I	929.6	103.1	20	1292.9	92.9	2420

*ЭМД-ын сангийн орлого ороогүй дүн

Сумдын эдийн засаг нийгмийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд, / үргэлжлэл /

(сумдаар)


сумдын нэр	Халдварт өвчний гаралт	10000 хүн амд	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1000 амьд төрөлтөд	Осол гэмтлийн өвчлөл, хүн	хүн амын нас баралт	Бүртгэлтэй эй ажилгүй чүүд	үүнээс эмэгтэй
хэмжих нэгж	тоо	тоо	хүн	хүн	хүн	хүн	хүн	хүн
ДҮН	20	2.4	2	15.0	58	18	790	414
Баруунтуруун						8	17	10
Бөхмөрөн						1	17	7
Давст	2	12.4					20	10
Завхан						2	24	12
Зүүнговь						5	28	18
Зүүнхангай						1	28	16
Малчин							40	15
Наранбулаг						1	36	18
Өлгий	1	4.1				1	53	27
Өмнеговь						4	14	8.0
Өндөрхангай							35	26
Сагил							16	11
Тариалан						1	53	21
Түргэн							36	11
Тэс	1	2.0				2	8	2
Ховд							17	8
Хяргас							15	7
Цагаанхайрхан	2	9.7					35	17
Улаангом	14	4.4	2	17.1	34	8	298	170
2020 I	60	6.0	2	13.2	45	33	789	427



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, 2021 оны эхний 1 сар



Өмнөд бүс
 Зүүн бүс
 Хойд бүс
 Баруун бүс
 Өмнөд захиргааны
 нутаг дэвсгэрийн
 хот



Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд,

147
Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд

23
Бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажилд орсон хүн

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, 2021 1 сар

		2018 I		2019 I		2020 I		2021 I		2021 I
		Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	2020 I хувь
Өмнөх сарын эцэст байсан ажилгүйчүүд		777	386	596	318	701	352	831	433	118.5
Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд		574	258	685	366	799	427	790	414	98.9
Хөгжлийн бэрхшээлтэй ажилгүйчүүд		4	3	12	7	15	6	21	8	140.0
Насны бүлгээр	15-24	129	64	93	50	105	50	93	57	88.6
	25-34	193	100	273	165	338	191	366	193	108.3
	35-44	134	64	166	86	198	118	197	111	99.5
	45-54	95	30	126	59	132	63	116	53	87.9
	55-59	22	0	24	6	24	4	15	-	62.5
	60+	1	0	3	0	2	1	3	-	150.0
Оны эхэнд байсан ажилгүйчүүд		777	386	596	318	701	352	831	433	118.5
2021 онд шинээр бүртгүүлсэн		129	61	157	81	308	171	147	92	47.7
Шинээр тухайн сард бүртгүүлсэн ажилгүйчүүд		129	61	157	81	308	171	147	92	47.7
2021 онд бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд орсон ажилгүйчүүд		2	1	20	10	33	24	23	13	69.7
Бүртгэлтэй ажилгүйчүүдээс тухайн сард ажилд орсон иргэд		2	1	20	10	33	24	23	13	69.7
2021 онд ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд		332	189	68	33	212	98	188	111	88.7
Ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс тухайн сард хасагдсан иргэд		332	189	68	33	212	98	188	111	88.7

АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, боловсролоор

	2018 I	2019 I	2020 I	2021 I	2021 I
					2020 I хувь
Ажилгүйчүүд бүгд	574	685	799	790	98.9
- дээд, магистр	142	172	214	227	106.1
- тусгай дунд	18	17	28	10	35.7
- мэргэжлийн анхан шатны	76	60	87	93	106.9
- бүрэн дунд	226	295	307	281	91.5
- бүрэн бус дунд	57	72	83	83	100.0
- бага	21	36	45	50	111.1
- боловсролгүй	34	33	35	46	131.4

Эх үүсвэр: Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын мэдээлэл

АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭ, ажил мэргэжлийн ангилалаар, давхардсан тоогоор

Д/д	Ажил, мэргэжлийн ангиллаар	/ажлын байрны захиалга/								
		2018 I		2019 I		2020 I		2021 I		2021 I
		Бүгд	Дүнд эзлэх хувь	Бүгд	Дүнд эзлэх хувь	Бүгд	Дүнд эзлэх хувь	Бүгд	Дүнд эзлэх хувь	2020 I Хувь
	Бүгд	2	100.0	73	100.0	97	100.0	44	100.0	45.4
1	Менежер	2	100.0					3	6.8	
2	Мэргэжилтэн			11	15.1	29	29.9	24	54.5	82.8
3	Техникч болон туслах /дэд мэргэжилтэн			11	15.1	8	8.2	6	13.6	75.0
4	Контор, үйлчилгээний ажилтан			6	8.2	1	1.0	1	2.3	100.0
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан			4	5.5	20	20.6	6	13.6	30.0
6	ХАА, ой, загас агнуурын ажилтан					0	0.0	0	0.0	
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний			36	49.3	29	29.9	3	6.8	10.3
8	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч			3	4.1	4	4.1	0	0.0	0.0
9	Энгийн ажил мэргэжил			2	2.7	6	6.2	1	2.3	16.7
10	Зэвсэгт хүчний ажил, мэргэжил									

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээлэл

АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭ, салбараар, давхардсан тоогоор 2021 он 1 сар

/захиалга/

Д/д	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2018 I		2019 I		2020 I		2021 I		2021 I
		Бүгд	Дүнд эзлэх хувь	Бүгд	Дүнд эзлэх хувь	Бүгд	Дүнд эзлэх хувь	Бүгд	Дүнд эзлэх хувь	Хувь
	Бүгд	2	100.0	73	100.0	97	100.0	44	100.0	45.4
1	ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур,			1	1.4		0.0		0.0	
2	Уул уурхай олборлолт					33	34.0		0.0	
3	Боловсруулах үйлдвэрлэл			4	5.5		0.0		0.0	
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалт			1	1.4		0		0.0	
5	Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа			3	4.1		0		0.0	
6	Барилга			1	1.4		0.0		0.0	
7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ			3	4.1	4	4.1		0.0	
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа			3	4.1		0.0		0.0	
9	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ			4	5.5	1	1.0		0.0	
10	Мэдээлэл, холбоо			6	8.2		0.0		0.0	
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа				0.0	2	2.1	3	6.8	150.0
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа			47	64.4		0	1	2.3	
13	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа					1	1.0		0.0	
14	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа					5	5.2	8	18.2	160.0
15	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал					3	3.1	4	9.1	133.3
16	Боловсрол					7	7.2	12	27.3	171.4
17	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа					2	2.1	3	6.8	150.0
18	Урлаг, үзвэр, тоглоом наадам					1	1.0		0.0	
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа					38	39.2	13	29.5	34.2
20	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн нэр төрлөөр нь салгаж тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	2	100.0	-	-		0		0.0	
21	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0	0.0	-	-	-	-	-	-	

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээлэл

АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭ, байгууллагын өмчийн болон хариуцлагын хэлбэрээр, 2021 он

Хэлбэр	2018 I		2019 I		2020 I		2021 I		2021 I	
	Бүгд	Дүнд эзлэх хувь	Бүгд	Дүнд эзлэх хувь	Бүгд	Дүнд эзлэх хувь	Бүгд	Дүнд эзлэх хувь	Хувь	
Төрийн	Бүгд	2	100.0	73	100.0	97	100.0	44	100.0	45.4
	Өмчийн		0.0	17	23.3	43	44.3	35	79.5	81.4
	Өмчийн оролцоотой		0.0		-		0.0		0.0	
	Төрийн хамтарсан		0.0		0.0	2	2.1		0.0	
Орон нутгийн	Өмчийн		0.0		-		-		-	
	Өмчийн оролцоотой		-		-		-		-	
	Орон нутгийн хамтарсан		-		-		-		-	
Хувийн	Монгол Улсын иргэний	2	100.0	55	75.3	52	53.6	9	20.5	17.3
	Хувийн хамтарсан		0.0	1	1.4		0.0		0.0	
	Хувийн гадаад улсын	-	-		-		-		-	
Байгууллагын хариуцлагын хэлбэрээр:	Хувьцаат компани	0	0.0	1	1.4		0.0		0.0	
	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	2	100.0	49	67.1	45	46.4	5	11.4	11.1
	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл				0.0		0.0		0.0	
	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл				0.0		0.0		0.0	
	Хоршоо		0.0	1	1.4	9	9.3		0.0	
	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар		0.0		0.0	3	3.1	1	2.3	
	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар		0.0		0.0					
	Төсөвт байгууллага		0.0	17	23.3	40	41.2	33	75.0	82.5
	Төрийн бус байгууллага				0.0		0.0		0.0	
	Бусад		0.0	5	6.8		0.0	5	11.4	

